

**МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД Н. АЛТАНХУЯГИЙН
ЭДИЙН ЗАСГИЙН ФОРУМЫН ХААЛТЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОЖ ХЭЛСЭН ҮГ**

2008 оны 10 дугаар
сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

Дэлхийн банкны дэд ерөнхийлөгч эрхэм хүндэт ноён Жеймс Адамс аа,

Эрхэм хүндэт зочид оо,

Дэлхий дахинаар санхүүгийн зах зээлийн хямралын талаарх таагүй мэдээлэл түгэж байгаа, түүнийг намжаан, зогсоохын тулд дэлхийн улс орнууд, олон улсын банк, санхүүгийн байгууллагууд хамтран оюун санаагаа уралдуулж байгаа энэ цаг мөчид, нөгөө талаар Монгол улсын хөгжлийн нэгэн чухал гарааны цэгт тулгарч байгаа энэ чухал цаг үед Дэлхийн банк, түүний суурин төлөөлөгчийн газраас санаачлан зохион байгуулж байгаа Эдийн засгийн форумын ач холбогдол нэн өндөр болохыг юуны өмнө онцлон тэмдэглэж байна.

Энэхүү форумд өндөр ач холбогдол өгч, ховорхон цагаа зарцуулан хүрэлцэн ирж, өөрсдийн үнэ цэнтэй мэдлэг туршлагаасаа бидэнтэй хуваалцаж байгаа Дэлхийн банкны Монгол улсыг хариуцсан захирал ноён Дэвид Доллар, Дэлхийн банкны Ерөнхий эдийн засагч Жастин Лин, ОХУ-ын Шилжилтийн эдийн засгийн хүрээлэнгийн захирал ноён Егор Гайдар, Австралийн Адилейдын Их сургуулийн профессор, ноён Ричард Помфрет нарт энэхүү форумд оролцогчдынхоо нэрийн өмнөөс болон Засгийн газрынхаа өмнөөс баярлаж, талархаж байгаагаа илэрхийлж байна.

Зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжих шилжилтийн үеийн хүндрэл бэрхшээлийг туулсаар яваа, цаашдын шинэ хөгжлийн замаа тодорхойлохоор оролдож, улс орноо аль болох эрсдэл багатайгаар хөгжлийн шинэ түвшинд гаргахыг зорьж байгаа Монголчууд бид бүхний хувьд бидэнтэй ижил төстэй шилжилтийн замыг туулан гарсан улс орнуудын бодитой туршлага, зөвлөмж нэн чухал гэдэгт форумд оролцогчид бүхэлдээ санал нэгтэй байлаа.

Сүүлийн сар гаруйн хугацаанд дэлхий нийтээрээ бид бүхэн хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр олон улсын санхүүгийн зах зээлийн гол төлөв **“улаан өнгөт**

мэдээлэл” буюу хөрөнгө, түүхий эдийн биржийн уналт, сааралтыг илтгэсэн мэдээг олонтаа харж, сонсож, сэтгэл зовних боллоо. Ийнхүү өргөн хүрээг хамарч байгаа санхүүгийн хямрал нь зөвхөн томоохон улс орнууд, үндэстэн дамнасан хөрөнгө оруулалтын банк, санхүүгийн байгууллагуудыг алдагдал, дампууралд оруулаад л өнгөрч байгаа хэрэг бус энэхүү гамшигт үзэгдэлийн цаана хөгжиж байгаа болон буурай хөгжилтэй улс орнуудын олон зуун сая ядуу, зүдүү иргэдэд ногдох орлого, тэдэнд хүрэх ёстой байсан тусламж дэмжлэг тасалдаж, хомсдож байгаад Монгол улсын Засгийн газар ихээхэн санаа зовниж, харамсаж байна.

Саяхан Вашингтон хотноо болсон ОУВС, Дэлхийн банкны жилийн уулзалтын үеэр ОУВС-ын гүйцэтгэх захирал Доминик Струас Хааны **“Санхүүгийн хямралыг даван туулахын тулд дэлхий нийтийн хамтын ажиллагаа чухал бөгөөд үүний зэрэгцээ тухайн улс орны эдийн засагт учирч болох хохирлыг багасгахын тулд Засгийн газрууд бүхий л бололцоот арга хэрэгслэлийг ашиглах ёстой”** гэж хэлсэн билээ.

Мөн түүнчлэн Европын Комиссын Ерөнхийлөгч ноён Жозе Мануэл Барросогийн хэлсэнчлэн **“Дэлхий нийтээрээ бид нэг завин дээр байна, цааш хамтдаа сэлэх үү, эсвэл хамтдаа живэх үү гэсэн асуулт бидэнд тулгараад байна”** гэсэн үзэл бодолтой бид нэг саналтай байна.

Санхүүгийн хямрал гүнзгийрч түүний сөрөг үр дагавар, нөлөөлөлд хамрагдахгүй үлдэх улс орон байхгүй гэдэгт олон улсын байгууллагууд, улс орны тэргүүн нар санал нэгдэж байна. Энэхүү хямралаас дэлхий нийтийн хамтын хүчин чармайлтаар гарах учиртай.

Өнгөрсөн долоо хоногт Бээжин хотноо зохион байгуулагдсан Ази, Европын дээд хэмжээний уулзалтад Монгол улсын Ерөнхийлөгч оролцсон билээ. Тус уулзалтаас гаргасан уриалга, санхүүгийн хямралыг таслан зогсоох, үр дагаварыг арилгахын төлөө улс орнууд, олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын нягт хамтын ажиллагаа нэн чухал болохыг Монгол улс бүрэн дэмжиж байна.

Үүний зэрэгцээ өндөр хөгжилтэй болон хөгжиж байгаа томоохон 20 улс орны тэргүүн нар ирэх сарын 15-ны өдөр Вашингтон хотноо хуран чуулж, дэлхий нийтийг хамраад буй санхүүгийн хямралыг хэрхэн таслан зогсоох арга хэмжээний талаар болон цаашид ийм өргөн хүрээг хамарсан санхүүгийн хямрал үүсгэхгүй байх үүднээс

Олон улсын түвшинд санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглүүлэн ОУВС-г өөрчлөн зохион байгуулах талаар зөвлөлдөх гэж байгаа нь улс орон бүрийн хувьд тун ач холбогдолтой үйл явдал болно гэж бид үзэж, энэхүү уулзалт, зөвлөгөөнөөс санхүүгийн хямралыг таслан зогсоох талаар тодорхой, үр дүн бүхий шийдвэр гаргаж чадна гэдэгт итгэж байна.

Хэдийгээр Монгол улс дэлхийн болон Азийн эдийн засагт эзлэх хувийн жингээр харьцангуй бага боловч санхүүгийн зэх зээлийн хямралыг гэтлэн давахын төлөө дэлхийн улс орнуудтай нэгэн сэтгэл, санаатай байж, хямралыг цаашид газар авхуулалгүй намжаах, таслан зогсоох үйл ажиллагаанд өөрийн гэсэн хувь нэмэрийг оруулах ёстой гэж манай Засгийн газар үзэж байна. Үүний тулд бид болж байгаа үйл явцыг анхааралтай ажиглан, судалж, бусад улс орнуудын авч хэрэгжүүлж байгаа санхүүгийн үр дүнтэй арга замуудыг судалж, өөрийн оронд тулгарч болох таагүй үр дагавараас урьдчилан сэргийлэх арга замаа төлөвлөн гаргаж, хэрэгжүүлж байна.

Өнөөгийн байдлаар дээрх санхүүгийн хямралын улмаас манай улсын эдийн засаг, санхүүгийн байдалд ч зарим таагүй, сөрөг нөлөөллүүд нь мэдрэгдэж эхлээд байна. Тухайлбал: манай улсын экспортын гол түүхий эд болох зэсийн үнийн түүхий эдийн зах зээлд үргэлжилсээр байгаа уналт, экспортын орлогын бууралт, өсөн нэмэгдэж байгаа гадаад худалдааны тэнцлийн алдагдал, төсвийн орлогын бууралт, төсвийн тэнцлийн алдагдал гэх мэт.

Манай Засгийн газар үүссэн нөхцөл байдлын талаар шуурхай авч хэлэлцээд урьдчилан сэргийлэх, үүсч болох хохирол, алдагдлыг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөгөө гарган ажиллаж байна. Үүнд: санхүүгийн тогтолцооны эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, олон улсын болон дотоодын санхүүгийн байдалд байнгын ажиглалт, судалгаа хийх, банк, санхүүгийн байгууллагуудад тавих хяналт шалгалтыг сайжруулах, цаашид үүсэж болох эрсдэлийг урьдчилан тодорхойлох, гарах арга замыг төлөвлөсөн байх зэрэг арга хэмжээг авч эхлээд байна.

Ашигт малтмал, үүний дотор цөөн тооны түүхий эдийн экспортод тулгуурласан эдийн засгийн явцуу бүтэцтэйгээр удаан хугацаанд хөгжих боломжгүй гэдгийг олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын зүгээс бидэнд хэдэн жилийн урьдаас анхааруулж, сануулж байсан явдалд бид талархаж байна. Үүний үр дүнд Монгол улс өнөөдөр ашигт малтмалын үнийн огцом бууралтаас хамгаалах арга хэрэгсэл, нөөц

санг байгуулж, хөрөнгө хуримтлуулсан нь учирч болох сөрөг үр дагаварыг бууруулахад чухал арга хэрэгсэл болохоор байна.

Монгол улсын хөгжүүлэх сангийн зохих хэсэг болох тогтворжуулалтын зориулалтаар хуримтлуулсан орлого нь өнөөгийн байдлаар Монгол улсын төсвийн нэг сарын орлогыг бүрэн нөхөхүйц хэмжээнд хүрээд байна.

Олон улсын санхүүгийн тогтолцоонд үүсээд байгаа хямрал нь зарим улс төрчид, судлаачдын үзэж байгаагаар цаашид багагүй хугацаанд үргэлжилж болзошгүй байгаа тул Монгол улс ч гэсэн өөрийн банк, санхүүгийн тогтолцооны аюулгүй байдлыг бэхжүүлэх зорилгоор банк, санхүүгийн харилцааг зохицуулж буй эрх зүйн орчныг сайжруулах, бүрдүүлэх чиглэлээр шуурхай арга хэмжээг авч байна. Үүний дотор арилжааны банкуудад хадгаламж эзэмшиж байгаа иргэд, байгууллагын хадгаламжийг аливаа болзошгүй эрсдэлээс хамгаалах даатгалын тогтолцоог нэн яаралтай бүрдүүлэх шаардлагатай гэж үзэж холбогдох хуулийг УИХ-ын чуулганаар ойрын хугацаанд хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.

Мөн түүнчлэн санхүүгийн тогтвортой байдлыг хангах нь зөвхөн Засгийн газрын дангаар хүлээх үүрэг биш тул Төвбанк, Санхүүгийн зохицуулах хороотой хамтран ажиллах Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагааг хууль эрх зүйн хувьд баталгаажуулан, үйл ажиллагааг нь эрчимжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Монгол улсын ойрын ирээдүйн хөгжилд ашигт малтмалын салбар ихээхэн чухал үүрэг гүйцэтгэхээр байгаа боловч Дэлхийн банкны ахлах эдийн засагч ноён Жастин Линий илтгэлдээ анхааруулсанчлан сайтар төрөлжөөгүй, цөөн нэр төрлийн ашигт малтмалын орлогод тулгуурласан эдийн засгийн бүтэц нь улс орны макро эдийн засгийн тогтолцоог тун хялбархан эдийн засгийн сааралт, зогсонги байдалд хүргэж болзошгүй юм гэдгийг бид анхаарч ирэх жилүүдэд эдийн засгийн төрөлжилт, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгоход ихээхэн анхаарал хандуулах шаардлагатай болох нь энэ өдрүүдэд улам бүр тодорхой болж байна.

Эрхэм нөхөд өө,

Монгол улсын Засгийн газар байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулж эхэлснээс хойш нэг сар гаруйн хугацаа өнгөрч байна. Энэ хугацаанд Засгийн газрын залгамж

чанарыг хадгалж өдөр тутмын үйл ажиллагааг явуулж ирсний зэрэгцээ Засгийн газрын ирэх дөрвөн жилд хэрэгжүүлэх зорилтууд, үйл ажиллагааны төлөвлөгөөгөө боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлээд байна.

Ирэх жилүүдэд манай Засгийн газрын баримтлах бодлого, хэрэгжүүлэх үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлээ бид ашигт малтмалын нөөцийг эргэлтэд оруулах, үйлдвэржилтийг хэрэгжүүлж эдийн засгийн өсөлтийг хангах, макро эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, мэдлэг ур чадвар бүхий мэргэжилтэй ажиллах хүчийг олноор бэлтгэх явдал гэж үзэж байна.

Хэдийгээр Монгол улс 1990-ээд оноос зах зээлийн эдийн засгийн шилжилтийг эхэлж, өнгөрсөн жилүүдэд улс төр, эдийн засгийн хүрээнд ихээхэн ололт, амжилтыг олоод байгаа боловч зах зээлийн эдийн засгийн суурь харилцааг бэхжүүлэх, төрийн оролцоо багатайгаар өөрийгөө аваад явах хэмжээний бизнесийн тогтолцоог сайтар бүрдүүлж чадаагүй байгаа нь өнгөрсөн хугацаанд олон бодит жишээн дээр харагдаж байна.

Бид дотоодын зах зээлээс бүрэн хангах боломжтой хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүний хомсдолт байдал, хувийн хэвшлийн бизнесийг өргөжүүлэхэд нэн шаардлагатай гадаад худалдааны дэд бүтцийг хөгжүүлэх, аж ахуй эрхлэх шатанд учирч байгаа хүндрэл чирэгдэлийг багасгах, арилгах тал дээр тун олон зүйлийг хийх өөрчлөх шаардлагатай байгаа нь өдөр тутам мэдрэгдэж байна. Нөгөө талаар олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас жил бүр эрхлэн гаргаж байгаа Эдийн засгийн эрх чөлөө, бизнес хөрөнгө оруулалтын орчин, өрсөлдөх чадварыг илэрхийлсэн судалгааны тайлангуудад манай бизнес, эдийн засгийн салбарт оршиж байгаа дутагдал, дэд бүтцийн сул хөгжлийн талаар маш тодорхой судалгаан дээр үндэслэн дүгнэсэн байгааг бид анхаарч, сургамж авч байна.

Иймээс Монгол улсын Засгийн газар ирэх 4 жилд зөвхөн шинэ зорилтууд тавих төдийгүй эдгээр нийгэм, эдийн засгийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд нэн шаардлагатай суурь бүтэц, тогтолцоог зөв хөгжүүлэх, бэхжүүлэх чиглэлээр томоохон ахиц дэвшил гаргах нь бүх салбарт эн тэргүүнд анхаарах ёстой зүйл гэж үзэж байна.

Бизнес эрхлэгчдэд үйл ажиллагаагаа явуулахад нь шаардлагатай байгаа хөрөнгө оруулалт, бизнесийн таатай орчныг бүрдүүлээгүй атлаа тэднээс олон төрлийн татвар, хураамж, шимтгэлийг цаг хугацаанд нь бүрэн төлөхийг шаарддаг

байдал, үүний хамтаар төрөөс үзүүлж буй аливаа үйлчилгээндээ хүнд суртал, чирэгдэл гаргадаг байдлыг таслан зогсоох шаардлагатай гэж Засгийн газар үзэж байна.

Монгол улс цаашид зөвхөн ашигт малтмалаар баян улс байгаад зогсохгүй, ашигт малтмал, баялагаа зөв ухаалагаар ашиглаж чаддаг, хүний хүч нөөцөө зөв дайчлан ашиглаж улс орны хөгжлөө хурдасгаж чаддаг, төр ба иргэний нийгэм нь хамтран аливаа тулгарсан асуудлыг шийдвэрлэж чаддаг дундаж орлоготой улс орон болохын төлөө бид чармайн ажиллах болно.

Бидний боловсруулсан үйл ажиллагааны хөтөлбөр нь зөвхөн хэрэгжүүлэх зорилтууд төдийгүй, түүнд хүрэх арга зам, хүрвэл зохих үр дүн, ирэх жилүүдэд тохиолдож болзошгүй эрсдэлийг тооцож тусгасан зэрэг онцлогуудтай юм.

Зорилт тавих нэг хэрэг, түүнийг амжилттай хэрэгжүүлнэ гэдэг бол цаг хугацаа, хүн хүч, хөрөнгө эх үүсвэр, зөв зохион байгуулалт шаардсан хамгийн эгзэгтэй чухал асуудал билээ. Иймд бид зөвхөн сайхан зорилтууд тавиад орхих бус түүнийгээ хэрхэн, ямар арга замаар амжилттай хэрэгжүүлж үр дүнд хүргэх вэ гэдэгт онцгой анхаарч ажиллаж байна.

Эрхэм нөхөд өө,

Энэ удаагийн форумын үйл ажиллагаа ийнхүү өндөрлөж байгаа боловч цаашид бусад олон улсын байгууллага, түнш орнуудтайгаа хамтран цаашид ийм хэлбэрийн үр ашигтай, өгөөжтэй, эдийн засаг, санхүүгийн уулзалт, форумыг үе шаттайгаар үргэлжлүүлэх болно.

Форумын явцад олж авсан мэдээлэл, мэдлэг туршлага нь манай бодлого боловсруулагчид, бодлого тодорхойлогч нарт маш үнэ цэнтэй бөгөөд банк, санхүүгийн болон хөгжлийн бодлогоо цаашид улам илүү оновчтой зөв, алсын хараатай тодорхойлоход чухал ач холбогдолтой боллоо гэж би үзэж байна. Хуралдааны явцад гүн гүнзгий, өргөн агуулга бүхий сонирхолтой илтгэл тавьсан, санал бодлоо илэрхийлсэн бүх илтгэгч, оролцогчид та бүхэнд баярлалаа.

Дараа дараагийн уулзалт, хуралдаан Улаанбаатар хотноо зохион явагдахад Монгол улс хөгжлийн илүү өндөр амжилтанд хүрсэн, хүн амын маань амьжиргааны түвшин өнөөгийнхөөс илүү сайжирсан байх болно гэдэгт та бүхэн итгэж болно.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

----- o O o -----

